



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/107

Арвайхээр

Журам шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "а", Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 29, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны "Журам батлах тухай" 246 дугаар тогтоолоор батлагдсан "Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам"-ын 3.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Аймгийн Засаг даргын шийдвэр гаргах, мэдээлэх, хяналт тавих журам"-ыг нэгдүгээр, шийдвэр боловсруулах хяналтын дагалдах хуудас, хувийн хэргийн загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд) -т үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2018 оны "Аймгийн Засаг даргын шийдвэр гаргах, үр дүнг тооцох, мэдээлэх журам батлах тухай" А/717 дугаар захирамжийг хүчингүйд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

Аймгийн Засаг даргын 2024 оны 03
дугаар сарын 09-ны өдрийн 4104 дүгээр
захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШИЙДВЭР ГАРГАХ, МЭДЭЭЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь аймгийн Засаг даргын (цаашид Засаг дарга гэх) захирамжлалын баримт бичгийг (цаашид шийдвэр гэх) гаргахад Захиргааны ерөнхий хууль болон бусад хууль тогтоомжид заасан шаардлагын хүрээнд боловсруулж гаргах, нээлттэй, шуурхай, ил тод мэдээлэх, хэрэгжилтийг үр нөлөөтэй зохион байгуулах, үр дүнг тухай бүр тооцож байхад оршино.

1.2. Засаг даргын шийдвэр нь хуулиар олгогдсон эрх хэмжээний хүрээнд үндсэн үйл ажиллагааны болон хүний нөөцийн чиглэлээр захирамж, цаг үеийн арга хэмжээг шуурхай зохион байгуулах, эрчимжүүлэх, явц, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх зорилгоор албан даалгавар хэлбэрээр гарна.

1.3. Засаг дарга өөрийн санаачилгаар хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх дээд шатны байгууллага болон Засгийн газрын яам, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас өгсөн чиг үүргийг зохион байгуулах, Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, иргэдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх гэх мэт захиргааны байгууллагын үйл ажиллагааг тухайлан зохицуулснаас бусад харилцааг зохицуулсан шийдвэрийг гаргахад мөн энэхүү журмыг мөрдөнө.

1.4. Засаг даргын шийдвэрт Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Захиргааны ерөнхий хуулийн үзэл баримтлалын хүрээнд эрх бүхий албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа хуульд үндэслэх зарчим үйлчлэхээс гадна шийдвэр үр нөлөөтэй байх, иргэдэд чирэгдэлгүй байх зарчмыг баримтална.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт, шийдвэрт тавигдах шаардлага, хүчин төгөлдөр болох

2.1. Засаг даргын шийдвэрийг зохион бүрдүүлэх, боловсруулах, хуульд нийцүүлэх, түүний үнэн зөв, албан ёсны хүчинтэй байдлыг хангах, олон нийтэд мэдээлэх ажиллагааг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс, Төрийн захиргааны удирдлагын хэлтэс хэрэгжүүлж, шийдвэрийн үр дагаварт хяналт тавих чиг үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс хариуцан зохион байгуулна.

2.2. Засаг даргаас шийдвэр гаргах зөвшөөрөл авсны дараа төслийг дараах албан тушаалтнуудаас боловсруулж, Засаг даргад танилцуулна.

2.2.1. аймгийн Засаг даргын орлогч (хариуцах чиг үүргийн салбарт)

2.2.2. аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга;

2.2.3. аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга;

2.2.4. аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагийн дарга;

2.3. Сумдын Засаг дарга, түүний Тамгын газар, бусад төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс аймгийн Засаг даргын шийдвэр гаргуулах шаардлагатай тохиолдолд төрийн байгууллагын нэгдсэн удирдлагын зарчмыг баримталж, аймгийн Засаг даргын Тамгын газрын холбогдох чиг үүрэг хариуцсан хэлтэстэй хамтран төсөл боловсруулж, эрх бүхий албан тушаалтнаар уламжлуулан шийдвэрлүүлнэ.

2.4. Шийдвэрт тавигдах шаардлага

2.4.1. Шийдвэрийн төслийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн хүлээн авч үндэслэл ба захирамжлах хэсгийн зохицуулалтыг хянаж, шийдвэрт хяналтын дагалдах хуудас олгоно. Шаардлагатай тохиолдолд шийдвэрт хувийн хэргийг нээж, нөхцөл байдлын үнэлгээ хийн, хувийн хэрэгт хавсаргах шаардлагатай баримтуудыг бүрдүүлэх талаар төсөл боловсруулж, танилцуулах албан тушаалтанд зөвлөгөө өгч хувийн хэргийн бүрдүүлбэрийг хангуулна.

2.4.2. Засаг даргын шийдвэрийн төсөлд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа эрх зүйн акт (хууль, тогтоол, тушаал, захирамж гэх мэт) үндэслэл болгох бөгөөд эрх зүйн актын тэргүү, огноо, дугаар, зүйл, заалтын дэс дугаарыг тодорхой бичиж, монгол хэлний зөв бичих дүрмийг баримтлан, утга найруулгын алдаагүй төлөвлөсөн байх бөгөөд Засгийн газрын 2020 оны “Журам батлах тухай” 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-д заасан шаардлагыг мөрдөнө.

2.4.3. Шийдвэрийн төслийн үндэслэлд хууль тогтоомжоос гадна аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлагдсан 5 жилийн үндсэн чиглэл, Өвөрхангай аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн хөгжлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээг үндэслэл болгож болно.

2.4.4. Улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн, орон нутагт хорио цээрийн дэглэм тогтоосон үед аймгийн Засаг даргын шийдвэрийг шуурхай гаргах ажлыг зохион байгуулах ба бусад цаг үеийн шинжтэй хойшлуулашгүй шийдвэр гаргах ажиллагааг төсөл боловсруулсан албан тушаалтан холбогдох чиг үүргийн хэлтэстэй хамтран яаралтай хэрэгжүүлж, шийдвэрийн хяналтын дагалдах хуудас, хувийн хэргийн бүрдүүлбэрийг шийдвэр гарсны дараа бүрдүүлэлт хийж аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст хүлээлгэн өгнө.

2.4.5. Нийтээр дагаж мөрдүүлэх захиргааны хэм хэмжээ тогтоох шийдвэрийн төслийг Захиргааны ерөнхий хуульд заасан шаардлагын хүрээнд боловсруулах бөгөөд чиглэл хариуцсан байгууллага шийдвэрийн нөлөөллийн шинжилгээг хийж, иргэд, олон нийтээс санал авах ажиллагааг бүх олон талт хэлбэрийг ашиглан зохион байгуулж, шийдвэрийг гаргана.

2.4.6. Шийдвэр гаргах ажиллагааны явцад зохицуулалт хийх харилцаанаас хамаарч өмнө нь захирамжлалын баримт бичгээр сумын болон аймгийн Засаг даргын шийдвэр гарч байсан эсэхэд нөхцөл байдлын үнэлгээг хийх, давхардуулсан зохицуулалт хийсэн эсэх, өмнөх шийдвэрийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хүчингүй болгох, нэмэлт өөрчлөлт оруулах зэргээр нөхөн зохицуулалт

хийх зайлшгүй шаардлагатай талаар шийдвэрийн төсөлтэй танилцаж, санал дүгнэлт гаргах эрх бүхий албан тушаалтнаас санал гаргавал заавал хэрэгжүүлнэ.

2.4.7. Шийдвэрийн төслийг шинэчлэн боловсруулж байгаа, өмнөх шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа эсэхээс үл хамаарч шийдвэрийн төслийг шинээр дахин боловсруулж, хяналтын дагалдах хуудас, хувийн хэргийг нээж, эрх бүхий албан тушаалтнуудаар гарын үсэг зуруулсны дараа баталгаажуулж гаргана.

2.4.8. Шийдвэрийн төслийг эрх бүхий албан тушаалтнуудад танилцуулахдаа, хариуцсан салбарын чиг үүрэгт нь хамаарах Засаг даргын орлогч Тамгын газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга нарт заавал танилцуулж, гарын үсэг зуруулна. Эдгээр албан тушаалтнууд ажлын байран дээрээ эзгүй тохиолдолд шийдвэрийн төслийг чиглэл хариуцсан бодлогын хэлтсийн даргаар эцэслэн хянуулж гаргана.

2.4.9. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаас гарсан болон хойшлуулашгүй тохиолдлоор гарч байгаа шийдвэрийн төсөл дээр аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Хууль, эрх зүйн хэлтсийн дарга нар эцэслэн хянаж, гарын үсэг зурсан байна.

2.4.10. Эрх бүхий албан тушаалтнууд шийдвэрийн төсөлтэй танилцсан, санал дүгнэлт гаргасан тухай тэмдэглэл үйлдэж, гарын үсэг зурахдаа шийдвэрийн үр дагавараас хамаарч Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу ашиг сонирхлын зөрчилтэй эсэх талаарх мэдэгдэл, тайлбарыг гаргах, Төрийн болон албаны нууцын тухай хуулиар зохицуулсан журмыг хэрэгжүүлж ажиллана.

2.6. Шийдвэр хүчин төгөлдөр болох, мэдэгдэх

2.6.1. Шийдвэрийн төслийг эцэслэж, аймгийн Засаг даргаар хяналтын дагалдах хуудсан дээр гарын үсэг зуруулсны дараа бичиг хэргийн эрхлэгч, бичээч, Засаг даргын туслах нар хэвлэмэл хуудсан дээр буулгах ба төрийн албан ёсны хэлээр, найруулга зүй, зөв бичих дүрмийн алдаагүй, архив, албан хэрэг хөтлөлтийн стандартыг хангуулж, гарын үсэг, тамга, тэмдгээр баталгаажуулан, Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн шийдвэрт он, сар, өдөр, дугаарыг олгон бүртгэж, албан ёсны хүчин төгөлдөр байдлыг хангаж, шийдвэрийн төсөл, хяналтын дагалдах хуудас, хувийн хэргийн материалыг хүлээн авч, шийдвэрийн хоёрдугаар хувийг холбогдох байгууллагын албан тушаалтанд хүлээлгэн өгнө.

2.6.2. Засаг даргын шийдвэрийг ажлын гурав хоногт багтаан албажуулж гаргах ба шийдвэрийг 2 хувь үйлдэх, шаардлагатай тохиолдолд хүний нөөцийн, төсвийн болон захиргааны нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг 3 хувь үйлдэж болно.

2.6.3. Шийдвэрийн улмаас эрх ашиг нь хөндөгдөж болзошгүй, сөрөг нөлөөлөл бүхий шийдвэрт (Захиргааны ерөнхий хуулийн 37 дугаар зүйлийн 37.5) хяналтын дагалдах хуудас, хувийн хэрэг заавал нээх бөгөөд шийдвэр гарсны дараа холбогдох этгээдэд мэдэгдэх, гардуулах, гомдол гаргах харьяаллын талаар шийдвэрт тусгана.

2.6.4. Засаг даргын эцэслэн гаргахаар зөвшөөрч хяналтын дагалдах хуудсанд гарын үсэг зурсан төсөл болон хэвлэмэл хуудсан дээр буулгаж,

баталгаажсан шийдвэрт Засаг даргын зөвшөөрөлгүйгээр засвар, өөрчлөлт оруулахыг хориглоно.

2.6.5. Шаардлагатай тохиолдолд холбогдох сум, байгууллага, иргэнд шийдвэрийг хүргүүлэх, мэдэгдэх үйл ажиллагааг тухайн шийдвэрийг хэрэгжүүлэхээр үүрэг хүлээсэн байгууллага албан тушаалтан хариуцан гүйцэтгэнэ.

Гурав. Шийдвэр гаргах ажиллагаанд оролцогчийн эрх үүрэг

3.1. Засаг дарга шийдвэр гаргах бүрэн эрхээ дараах нөхцөлд Засаг даргын орлогчид түр шилжүүлнэ.

3.1.1. Ажлын 5-аас дээш хоногоор дотоод, гадаадад албан томилолтоор ажиллах

3.1.2. Ээлжийн амралтаа эдлэх

3.1.3. Өвчтэй болон бусад чөлөө эдлэх

3.2. Шийдвэр гаргах бүрэн эрхээ шилжүүлсэн үед Засаг даргын орлогч нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 29 дүгээр зүйлийн 29.1.2.б. в. г, 29.1.3.в ,ж,к, 29.1.5б, 30 дугаар зүйлийн 30.1.4, 30.1.5, 30.1.10, 30.1.11, 30.1.12, 30.1.13, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь заалтад тусгагдсан асуудлаар тус тус шийдвэр гаргахгүй.

3.3. Засаг дарга шийдвэр гаргах бүрэн эрхээ түр шилжүүлсэн тохиолдолд тийнхүү бүрэн эрхийг хүлээн авсан Засаг даргын орлогч харьяалах чиг үүргээс үл хамааран шилжүүлсэн бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргаж, үйл ажиллагаагаа эрхлэн явуулна.

3.4. Аймгийн Засаг даргын орлогчийн шийдвэр нь аймгийн Засаг даргын шийдвэрийн нэгэн адил хүчин төгөлдөр байна.

3.5. Засаг дарга 2 орлогчтой тохиолдолд шийдвэр гаргах бүрэн эрхийг аль нэг орлогчид хариуцуулах талаар заавал шийдвэр гаргана. Засаг даргын шийдвэрээс (захирамж) бусад захиргааны акт гаргах (албан бичиг, гэрээ, зөвлөмж, мэдэгдэл, албан шаардлага гэх мэт) ажиллагааг Засгийн газрын 2020 оны “Журам батлах тухай” 246 дугаар тогтоолоор батлагдсан “Албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-д заасан шаардлагын дагуу эрхлэн явуулна.

3.6. Аймгийн Засаг даргын орлогч, Тамгын газрын дарга, хэлтсийн дарга, мэргэжилтэн, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын эрх бүхий албан тушаалтнууд нь шийдвэр гаргах ажиллагааны талаарх хууль тогтоомж болон энэхүү журмаар хүлээсэн үүргийг хэрэгжүүлж, шийдвэрийн биелэлт, үр дагаварыг Засаг даргын өмнө хариуцна.

3.7. Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, хэлтсийн даргын эрх үүрэг:

3.7.1. Өөрийн харьяалах чиг үүргийн байгууллагаас ирүүлсэн шийдвэрийн төсөл мөн өөрийн санаачилгаар бусад салбарын шийдвэрийн төсөлтэй танилцаж, төсөлд санал, дүгнэлт өгөх;

3.7.2. Шийдвэр гаргахаас татгалзах тохиолдолд шалтгаан, үндэслэл, саналаа хяналтын дагалдах хуудсанд бичих, эсхүл Засаг даргад биечлэн танилцуулж, төслийг эргүүлэн татах;

3.7.3. Харьяалах асуудал болон Засаг даргын үүрэг болгосноор шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, тайлагнах;

3.7.4. Засаг даргын эрх хэмжээний хүрээ, хууль, тогтоомжид нийцээгүй шийдвэрийн төслийн талаар Засаг даргад тусгайлан танилцуулах;

3.7.5. Шийдвэрийн төсөлд шаардлагатай хууль тогтоомж, санхүү эдийн засаг, үр дүнгийн тооцоо, судалгааг хавсаргаж, төсөлтэй танилцах эрх бүхий албан тушаалтнуудад холбогдох мэдээллийг үнэн зөв тайлбарлах, мэдээллээр ханган, төсөлтэй танилцах хугацааг гаргаж өгөх;

3.7.6. Засаг дарга шийдвэрийн төслийг Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хуралдаанд төслийг танилцуулж, зөвлөлийн гишүүдийн саналын дагуу Засаг даргын оруулсан нэмэлт, өөрчлөлтийг тусган шинэчлэн найруулж дахин танилцуулах.

3.7.7. Хяналтын дагалдах хуудсанд нэр заагдсан албан тушаалтнуудад төслийг танилцуулж, тухайн шийдвэрийн агуулгын хүрээнд салбарын бодлого хариуцсан хэлтсийн даргад шийдвэрийн төсөл заавал танилцуулагдсан байх, гарсан санал дүгнэлтийг аймгийн Засаг даргад тусгайлан танилцуулж энэ талаар тэмдэглэл хөтлөн шийдвэрийн хувийн хэрэгт хавсаргах;

Дөрөв. Засаг даргын шийдвэрийн үр дагавар,
нийтэд мэдээлэх

4.1. Шийдвэрийн эрх зүйн үйлчлэл, үр дагаварыг тодорхойлохдоо Захиргааны ерөнхий хуулийн 33-36 дугаар зүйлийг удирдлага болгох бөгөөд шийдвэр нь захирамжилсан (хориглосон, зөвшөөрсөн, журамласан) шинжтэй байх ба эерэг нөлөөлөл, сөрөг нөлөөлөл бүхий шинжээс нь хамаарч шийдвэрийн эрх зүйн үйлчлэл, үр дагаварыг тодорхойлно.

4.2. Засаг даргын шийдвэрт нэмэлт өөрчлөлт оруулах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, эрх бүхий байгууллагаас шийдвэрийг хүчингүй болгох, эсхүл тухайн шийдвэрийн үйлчлэл ач холбогдлоо алдаж, дуусгавар болгох шаардлагатай эсэх талаар нөхцөл байдлын үнэлгээ хийгдэх хүртэл шийдвэрийн үйлчлэл хүчин төгөлдөр байна.

4.3. Шийдвэрийг нийтэд мэдээлэх, сурталчлах ажлыг шийдвэр гаргасан байгууллага, хариуцан зохион байгуулах бөгөөд мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсээс аймгийн албан ёсны цахим мэдээллийн хуудсанд тухай бүр байршуулж, лавлагаа, мэдээллийн сан бүрдүүлж, хүсэлт гаргасан байгууллага, иргэдэд шийдвэрийг хуулбарлан өгч үйлчилнэ.

4.4. Батлагдсан шийдвэрийг аймгийн албан ёсны цахим хуудсанд байршуулахаас өөрөөр Засаг даргын Тамгын газрын хэлтэс, Засаг даргын эрхлэх хүрээний газар, хэлтэс, алба, төрийн албан хаагчид бусад цахим орчинд эх хувь болон хуулбар хувиар байршуулах, хувийн сүлжээгээр олон нийтэд тараахыг хориглоно.

4.5. Шийдвэрийн үр дагавар, шийдвэрээр зохицуулж буй арга хэмжээнд шууд нөлөөлөхөөр бичилт, төсвийн тооцооллын алдаа, хууль зүйн үндэслэл, албан хэрэг хөтлөлтийн стандарт, утга найруулгын илэрхий алдааг шийдвэрийн үндсэн зохицуулалт, утга агуулгыг өөрчлөхгүйгээр шийдвэрийн төсөл санаачлагч байгууллагад мэдэгдэж шийдвэрийг Засаг даргын зөвшөөрлөөр алдааг залруулж, шийдвэрийг мэдэгдсэн этгээдэд залруулга бүхий хуулбарыг хуулбар үнэн тэмдэг дарж нэн даруй хүргүүлнэ.

4.6. Засаг даргын шийдвэр нь аймгийн нийт нутаг дэвсгэрт хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд, сум, баг, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх байгууллага, аж ахуйн нэгж, иргэд дагаж мөрдөх, заавал биелүүлэх үүрэгтэй тул шийдвэрийг сурталчлах, хэрэгжилтийг зохион байгуулах, үр дүнг үнэлэн дүгнэх, мэдээлэх ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх газар, хэлтэс, албад, сум, багийн Засаг дарга, сумын Засаг даргын Тамгын газар хариуцна.

4.7. Сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, Засаг даргын шийдвэрийн биелэлтийг хагас жил тутам тооцон гаргаж, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэст ирүүлж байна.

4.8. Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жилд нэг удаа Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, үр дүнг тооцно.

Тав. Нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан хэм хэмжээний актыг гаргах, улсын нэгдсэн санд бүртгүүлэх

5.1. Засаг даргын нийтээр дагаж мөрдүүлэхээр хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг (Захиргааны ерөнхий хуулийн 59 дүгээр зүйл) Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх үйл ажиллагааг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэс эрхлэн гүйцэтгэнэ.

5.2. Засаг даргын нийтээр дагаж мөрдүүлэх хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслийг санаачлагч болон боловсруулагч нь холбогдох хууль тогтоомж, журамд заасан шаардлагын дагуу тооцоо судалгаа, шинжилгээ, албан байгууллага, иргэдийн санал дүгнэлт, олон нийтийн хэлэлцүүлгийн баримт материалын хамт аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүлнэ.

5.3. Нийтээр дагаж мөрдүүлэх шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногт багтаан албан ёсны эх хувь түүний баталгаажуулсан 2 хувь хуулбарын хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсний дараа тухайн шийдвэр хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

5.4. Нийтээр дагаж мөрдүүлэх шийдвэрийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэдэд танилцуулан сурталчилсны дараа хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

Зургаа. Бусад зүйл

6.1. Засаг даргын шийдвэр гаргах ажиллагаанд оролцох, үүрэг хүлээсэн албан тушаалтнууд нь шийдвэр гаргах ажиллагааны журам зөрчсөн, эрх хэмжээ хэтрүүлсэн нь байгууллагын дотоод хяналт шалгалт болон эрх бүхий байгууллагын дүгнэлт, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол Төрийн албаны тухай

хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, байгууллагын дотоод журамд заасан хариуцлагыг хүлээнэ.


6.2. Засаг дарга өөрийн эрх хэмжээний хүрээнд хууль, тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрийг холбогдох үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнууд нь үр дүнтэй хэрэгжүүлэх, шийдвэрийн биелэлтийг тооцохдоо бусдын эрх ашгийг хөндөхгүй байх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг чанд баримтлан ажиллана.

6.3. Шийдвэрийн хэрэгжилттэй холбогдуулан албан байгууллага, иргэдээс гаргасан гомдлыг шийдвэрлэх, хууль хяналтын байгууллагаар асуудлыг шийдвэрлүүлж байгаа бол шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулсан албан тушаалтан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд Засаг даргыг төлөөлөн оролцоно.

6.4. Аймгийн Засаг даргын шийдвэрийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заагдсан хариуцлага хүлээлгэнэ.

-oOo-

Аймгийн Засаг даргын 2021 оны 03
дугаар сарын 29-ны өдрийн 11107 дүгээр
захирамжийн хоёрдугаар хавсралт



ХЯНАЛТЫН ДАГАЛДАХ ХУУДАС

20... оны.....дугаар сарын-ны өдөр

А. Шийдвэрийн төслийн нэр:

Б.Төсөл өргөн барьсан:

В.Танилцуулах албан тушаалтан:

1. Засаг даргын орлогч
2. Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Ганболд
3. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Н.Энхцэцэг
4. Хууль, эрх зүйн хэлтсийн дарга А.Отгонцэцэг
5. Тухайн чиг үүргийг хариуцсан Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга төслийг урьдчилан хянасан эсэх:

Г. Төслийг хянаж, дагалдах хуудас олгосон: Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн

Д. Санал, дүгнэлт өгөх:

д/д	Албан тушаал, нэр	Огноо	Санал, дүгнэлт

Эцэслэн гаргахыг зөвшөөрсөн:

ЗАСАГ ДАРГАА.ИШДОРЖ

20... оны дугаар сарын -ны өдөр

**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ШИЙДВЭР (ЗАХИРАМЖ)
ГАРГАХ АЖИЛЛАГААНЫ ХУВИЙН ХЭРЭГ**

1. Шийдвэр гарсан огноо.....
2. Шийдвэрийг хүлээн авсан огноо.....
3. Шийдвэрийг гардуулсан огноо.....

Д/д	ТӨРӨЛ	ТЭМДЭГЛЭЛ
1	Үйл ажиллагааны үндэслэл	
2	Үе шат	
3	Оролцогчийн санал	
4	Холбогдох баримт	
5	Сонсох ажиллагаа, уулзалт, хуралдааны тэмдэглэл	
6	Шийдэл	
7	Хүргүүлсэн, мэдэгдсэн баримт	
8	Шийдвэр боловсруулах оролцоо	
9	Гүйцэтгэлийн тухай дэлгэрэнгүй тэмдэглэл	

Хувийн хэрэг бүрдүүлсэн албан тушаалтны
.....(гарын үсэг).....(нэр)
20..... оны дугаар сарын -ны өдөр